



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/275

Хэрлэн сум

Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх
вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1 .3-ын “а”, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт өнгөрсөн 3 жил дараалан малын гоц халдварт хонины цэцэг өвчин оношлогдсонтой холбогдуулан уг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт хонин сүрэг болон 2018 онд шинээр гарсан хургыг зааврын дагуу вакцинжуулах ажлыг тарилга хүлээж авсан өдрөөс эхлэн 15 хоногт багтаан чанартай, шуурхай зохион байгуулсугай.

2. Уг ажилд багийн Засаг дарга, төрийн албан хаагчдыг томилон хяналт тавьж ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж, тарилгын дүн, санхүүжилтийн баримт материалыг холбогдох яаманд хүргүүлж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуй газар /Ж.Энх-Амгалан/-т, вакцинжуулалтын чанар, явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА